



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/131

Шивээговь сум

**Спортын бага наадам зохион байгуулах
комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар захирамж, сумын Засаг даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.5.1 дахь заалт “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд “Сумын Засаг даргын нэрэмжит спортын бага наадам” зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Л.Чанцалмаа
(1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Маналмаа

(2 дугаар багийн Засаг дарга)

Д.Баттуул
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Н.Амаржаргал
(Мэдээллийн технологи, олон нийттэй харилцах ажилтан)

Б.Баярцэцэг
(Нярав)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2. Спортын бага наадмын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, наадмын зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Наадамд зарцуулагдах 3,820,000 (гурван сая найман зуун хорин мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан арга хэмжээний зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4. Спортын бага наадамд иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүрэн хамруулж, иргэдэд зөв дадал хэвшил олгоход уриалан өндөр түвшинд зохион байгуулалттай ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 11 -р сарын 01 -ны өдрийн 11/031 дугаар захирамжийн 1-р хавсралт



СУМЫН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “СПОРТЫН БАГА НААДАМ”-ЫН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

Сум орон нутагт спортын хөгжлийг эрчимжүүлэх, албан байгууллага хамт олныг спортоор хичээлэх орчин нөхцлийг бүрдүүлэх дэмжих, тэдний дунд биеийн тамир, спортын нөхөрлөлийг бий болгох бэхжүүлэх, спортоор хичээллэгчдийн хүрээг тэлэх, багийн болон ганцаарчилсан тоглогч, зохион байгуулалтыг сайжруулах иргэдийн идэвхтэй хөдөлгөөнд уриалан Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хүрээнд уг наадмыг уламжлал болгон зохион байгуулахад оршино.

Хоёр: Хугацаа явагдах газар, зохион байгуулалт, заавар

2.1 Наадам 2024 оны 11 сарын 09-10 -ны өдрүүдэд сумын ЗДТГазар, Уурхайн спортын заал, 3 р сургуулийн спортын зааланд тус тус хуваарийн дагуу зохион байгуулагдана.

Наадамд сумын бүх аж ахуй нэгж байгууллагууд Төрийн болон ТББ-ууд иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагууд, хөдөлмөр эрхэлдэггүй иргэд, малчид ахмад настанууд *эмэгтэй 55 нас, эрэгтэй 60 нас*, хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамтран оролцох ба орон тоо бүтцийн хувьд баг бүрдүүлэх боломжгүй байгууллагууд хамтран оролцож болно.

Оюутан , ЕБС-ийн сурагч, тус суманд харьяалалгүй иргэн, дээд лигт тоглож байгаа болон наадамд оролцож байгаа төрөлдөө спортын дэд мастер, спортын мастер цолтой тамирчдыг оролцуулахгүй. Тэмцээн эхлэхэд талбайдаа бэлэн байх шаардлагатай ба 5 минутанд талбайд гараагүй багт 0 оноо өгнө

Нэг тамирчин спортын 3 хүртэлх төрөлд оролцох ба зөрчсөн тохиолдолд тухайн тамирны оролцсон сүүлийн төрлийн амжилтыг цуцлан багийн болон хувийн амжилтыг хүчингүйд тооцно.

Наадам сагсан бөмбөг, холимог волейбол, даам, ширээний теннис, дартс, олс таталт гэсэн 6 төрлөөр явагдана.

Наадмыг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон зохион байгуулах комисс удирдан зохион байгуулна.

2.2 Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаа

Тэмцээний нээлт 11-р сарын 09-ний өдөр 11⁰⁰ цагт Уурхайчдын спорт зааланд хийх тул үйл ажиллагаанд баг тамирчид жигд хувцас, логотой оролцоно /Багууд хаягтай жагсана.

2.3 Төрөл тус бүрийн товч заавар:

№	Спортын төрөл	Багийн бүрэлдэхүүн	Зохион байгуулах	Зохион байгуулах газар
1	Сагсан бөмбөг	Эрэгтэй-6, эмэгтэй- 6 тус бүр 1 дасгалжуулагчтай	Эр-8 мин I Эм-6 мин /2 үе/	Уурхайн зааланд
2	Волейбол	Холимог Эрэгтэй-3, эмэгтэй-3 тус бүр 1 дасгалжуулагчтай	21 оноогоор 2 ээлж	Сургуулийн спорт зааланд
3	Теннис	Эрэгтэй-1 Эмэгтэй-1		Уурхайн зааланд
4	Даам	Эрэгтэй-1 Эмэгтэй-1	Хасагдах системээр	ЗДТГ
5	Дартс	Эрэгтэй-1 Эмэгтэй-1	Хасагдах системээр	Уурхайн зааланд
6	Олс таталт	Холимог 5 эр,5 эм		Уурхайн зааланд

Гурав: Техникийн зөвлөгөөн журам, тавигдах шаардлага

3.1 Техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөн нь 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 17⁰⁰ цагт Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд болно Тус техникийн зөвлөгөөнд зохион байгуулах ажлын хэсэг багийн ахлагч нар оролцоно.

Техникийн зөвлөгөөнд багийн ахлагч нар тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг маягтын дагуу ирүүлнэ (мэдүүлгийн маягыг хавсаргав) Багийн мэдүүлэг ирүүлэхдээ тамирчдын цахим үнэмлэхний хуулбарыг хавсаргана

3.2 Тэмцээн зохион байгуулах, дүгнэх журам

3.2.1 Тэмцээнд оролцох баг тамирчид багийн ахлагчтай байна

3.2.2 Тэмцээний үеэр ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд тамирчид багийн ахлагчаар дамжуулан тухайн маргааныг шийдвэрлүүлнэ.

3.2.3 Тоглолтын дэг, хуваарь, эхлэх болон дуусах дарааллыг техникийн зөвлөгөөн дээр сугалаагаар тогтооно. Сугалаа сугалснаас хойш тэмцээнд өөр баг нэмж оруулахгүй.

3.2.4 Сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд оролцогч багуудыг А. В. С

хэсгүүдэд хувааж тойргоор явагдана.

3.2.5 Дараагийн шатанд шалгарсан багийг олимпийн системээр тоглуулж, төрөл тус бүрт аваргыг шалгаруулж байр эзлүүлнэ

3.2.6 Хэрэв тэмцээнд цөөн тооны баг оролцохоор бол техникийн зөвлөгөөн дээр ямар системээр тоглохыг шийдвэрлэнэ.

3.2.7 Тэмцээнд оролцох баг тамирчид энгэрийн болон арын хувийн дугаар бүхий тоглолтын жигд өмсгөлтэй цаг хугацаа болон тэмцээний зохион байгуулалтын шаардлагыг биелүүлэх, нээлтийн болон хаалтын үйл ажиллагаанд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцох, хаяг логотой байх зэрэг шаардлагуудыг хангасан байна.

Дөрөв. Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүн, заавар

Спортын бага наадамд албан байгууллага ААН-үүд сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй, эмэгтэй тус тусдаа тоглох ба дараах багийн бүрэлдэхүүнтэй оролцоно.

Үүнд:

1. ЗДТГ, ИТХ, Соёлын төв- хамтарсан баг
2. Шивээ-Овоо ХК, Шивээ сервис ХХК хамтарсан баг
3. 3-р цэцэрлэг, Илчлэг шивээ ОНӨААТҮГ- хамтарсан баг
4. 3-р сургууль- 1 баг
5. Эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсэг- хамтарсан баг
6. 1-р баг- 1 баг
7. 2-р баг- 1 баг
8. 21,22-р зөрлөгийн хамтарсан баг
9. Хаан банк, Төрийн банк, холбооны салбаруудын хамтарсан баг
10. Хувийн хэвшил, Бизнес эрхлэгчидийн хамтарсан баг


Тав. Шагнал, урамшуулал

Төрөл тус бүрд эхний 3 байр эзэлсэн баг, тамирчдыг медаль өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Спортын 6 төрлийн нийлбэр дүнг их онооны системээр дүгнэнэ.

- 1 р байр.....Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2 р байр.....Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3 р байр.....Өргөмжлөл, мөнгөн шагнал

Сумын Засаг даргын 2024 оны 11 -р сарын 09 -ны өдрийн 11/11 дугаар захирамжийн 2-р хавсралт



СУМЫН ИРГЭДИЙН ДУНДАХ "СПОРТЫН БАГА НААДАМ"-ЫН ЗАРДАЛ

№	Спортын төрөл	Эзлэх байрны тоо	Тоо хэмжээ	Шагналын дүн	Нийт
1	Сагсан бөмбөг /эр. эм/	1-р байр	2	60.000	120.000
		2-р байр	2	50.000	100.000
		3-р байр	2	40.000	80.000
2	Волейбол /эр. Эм холимог/	1-р байр	1	60.000	60.000
		2-р байр	1	50.000	50.000
		3-р байр	1	40.000	40.000
3	Теннис	1-р байр	2	30.000	60.000
		2-р байр	2	25.000	50.000
		3-р байр	2	20.000	40.000
4	Даам	1-р байр	2	30.000	60.000
		2-р байр	2	25.000	50.000
		3-р байр	2	20.000	40.000
5	Дартс	1-р байр	2	30.000	60.000
		2-р байр	2	25.000	50.000
		3-р байр	2	20.000	40.000
6	Олс таталт	1-р байр	1	60.000	60.000
		2-р байр	1	50.000	50.000
		3-р байр	1	40.000	40.000
7	Багийн нийлбэр дүнгээр тэргүүн байр	1	1	300.000	300.000
8	Багийн нийлбэр дүнгээр дэд байр	1	1	250.000	250.000
9	Багийн нийлбэр дүнгээр гутгаар байр	1	1	200.000	200.000
10	Медаль		102	12.000	1.224.000
11	Өргөмжлөл жааз		33	12.000	396.000
12	Шүүгч		4	100.000	400.000
Дүн					3.820.000